



Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2023 оны 01 дүгээр сарын 13-ны өдрийн А/12 дугаар тушаалын аравдугаар хавсралт

**№ 6.10. ГАЗРЫН ТОСНЫ АШИГЛАЛТЫН ҮЙЛ
АЖИЛЛАГААГ ШАЛГАХ ХЯНАЛТЫН ХУУДАС**

Хяналтын байгууллага:

Шалгуулагч этгээдийн нэр:

Объектын нэр:

Регистрийн дугаар:

Хяналт шалгалт эхэлсэн огноо:...../...../.....

Удирдамжийн дугаар:

Хяналт шалгалт эхэлсэн огноо:...../...../.....

Шаардлага хангасан асуултын тоо:

Хууль сахин мөрдөлтийн хувь:

Шаардлага хангаагүй нийт оноо:

Эрсдэл үүсэх магадлалын хувь:

Эрсдэл үүсэх магадлал

ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН АСУУЛТУУД, ҮНЭЛГЭЭ

№	Хууль тогтоомж, дүрэм, журам, стандартын нэр, зүйл, заалт	Асуултууд	Батлагдсан оноо		Авсан оноо	Гүйцэтгэл-ийн шалгалт
			Шаардлага хангасан	Шаардлага хангаагүй		
1		2	3	4	5	6
Ерөнхий заалт						
1	Газрын тосны тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.3 дахь хэсэг	Газрын тосны ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй.				
2	Газрын тосны тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.4.4 дэх заалт	Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээтэй.				
3	Газрын тосны тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.3 дахь хэсэг	Төрийн захиргааны төв байгууллагын баталсан газрын тосны орд ашиглалтын үйл ажиллагааны				
4	Газрын тосны тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.4.2 дахь заалт, 25 дугаар зүйлийн 25.8 дахь хэсэг	Тухайн жилд гүйцэтгэх ажлын төлөвлөгөө, төсвийн төсөлтэй				
5	Газрын тосны тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2.2 дахь заалт	Гэрээнд заасан үйл ажиллагааг явуулдаг	0	9		
6	Газрын тосны тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.8 дахь хэсэг	Гэрээлэгч ашиглалтын хоёр дахь жилээс эхлэн тухайн жилийн ашиглалтын төлөвлөгөө, төсвийн төслийг хуанлийн өмнөх жил дуусахаас 90 хоногийн өмнө төрийн захиргааны байгууллагад ирүүлдэг	0	9		
7	Газрын тосны тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2.5 дахь заалт	Өөрийн үйл ажиллагаанд шаардагдах бараа, ажил, үйлчилгээ худалдан авах, туслан гүйцэтгэгч сонгохдоо Монгол Улсад бүртгэлтэй татвар төлөгч аж ахуйн нэгжид тэргүүн ээлжинд давуу эрх олгодог.	0	9		

8	Газрын тосны тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2.7 дахь заалт	Үйл ажиллагаандаа дэвшилтэт технологи нэвтрүүлэх, Монгол Улсын иргэн-мэргэжилтэн, мэргэжлийн ажилчдыг ажилд авах, сургах, дадлагажуулах, газрын тосны салбарт хэрэгжүүлж байгаа үйл ажиллагаа, үр дүнг олон нийтэд таниулахад төрийн захиргааны байгууллагатай хамтарч ажилладаг	0	9		
9	Газрын тосны тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2.8 дахь заалт	Ижил төрлийн ажил хөдөлмөр эрхлэгч гадаад, дотоодын ажилтны цалин, урамшууллыг тэгш тогтоох, түүнчлэн ажилтны хууль ёсны эрх, ашиг сонирхлыг хамгаалдаг	0	9		
10	Газрын тосны тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2.9 дэх заалт	Байгаль орчныг нөхөн сэргээх үүргээ бүрэн гүйцэд биелүүлэх, ашиглалтын барилга байгууламжийг татан буулгах баталгаа болгон тухайн жилийн ашиглалтын үед гэрээлэгчид ногдох ашигт газрын тосны нэг хувьтай тэнцэх мөнгөн хөрөнгийг жил бүр төлөвлөгөө батлагдсанаас хойш 60 хоногийн дотор Монгол Улсад үйл ажиллагаа явуулдаг банкны эскроу дансанд байршуулдаг	0	9		
11	Газрын тосны тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2.11 дэх заалт	Ашиглалтын үйл ажиллагаанд шаардагдах автомашин, техник, тоног төхөөрөмж, материал түүхий эд, сэлбэг хэрэгсэл, газрын тосны бүтээгдэхүүнийг импортлохдоо тэдгээрийн нэр төрөл, тоо хэмжээ, нэгж үнийн мэдээлэл, түүнчлэн Монгол Улсын нутаг дэвсгэрт барьж байгуулах барилга байгууламжийн зураг төсөл, техникийн баримт бичгийг төрийн захиргааны байгууллагад гаргаж өгдөг	0	9		
12	Газрын тосны тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2.13 дахь заалт	Газрын тосны нөөцийн хөдөлгөөний тооцоог жил бүр гаргаж, төрийн захиргааны байгууллагаар хянуулдаг	0	9		
13	Газрын тосны тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2.15 дахь заалт	Үйл ажиллагааных нь явцад түүх, соёлын олдвор, эд өлгийн зүйл илэрсэн тохиолдолд тухайн газарт явуулж байгаа үйл ажиллагаагаа зогсоон, нэн даруй холбогдох байгууллагад мэдэгддэг	0	9		
14	Газрын тосны тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2.17 дахь заалт	Байгаль орчныг хамгаалах, орон нутгийн хөгжилд сайн дурын үндсэн дээр дэмжлэг үзүүлэх асуудлыг тусгасан гэрээг тухайн тусгай зөвшөөрлийн талбай орших сум, дүүргийн Засаг даргатай байгуулж ажилладаг	0	9		

15	Газрын тосны тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2.19 дэх заалт	Газрын тосыг орон нутаг, улсын болон олон улсын чанартай замд хүргэх замын төрөл түүнчлэн байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлт хийх, ашиглалтын барилга байгууламжийг татан буулгахад шаардагдах хөрөнгийг орд ашиглах үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгадаг	0	9		
16	Газрын тосны тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1 дэх хэсэг	Гэрээлэгч бүтээгдэхүүн хуваах гэрээний эрх, үүргийг бүхлээр нь, эсхүл гуравны нэг буюу түүнээс дээш хувийг Засгийн газрын зөвшөөрөлгүйгээр шилжүүлдэггүй	0	9		
17	Газрын тосны тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.7 дахь хэсэг	Гэрээлэгч болон гэрээний эрх, үүргийг шилжүүлэн авч байгаа этгээд эрх, үүрэг шилжүүлэхэд төлсөн төлбөрийн хэмжээг шударгаар мэдээлдэг	0	9		
18	Газрын тосны тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.6 дахь заалт	Ашиглалтын тусгай зөвшөөрөл олгосноос хойш 90 хоногийн дотор хуульд заасны дагуу ашиглалтын талбайн хилийн хэмжилт хийж, шав тэмдэг тавих ажлыг холбогдох мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлдэг	0	9		
19	Газрын тосны тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.4 дэх хэсэг	Гэрээлэгч бүтээн байгуулалтын ажлыг гүйцэтгэхдээ дэд бүтэц, байгаль орчны асуудлаар холбогдох төрийн захиргааны төв болон төрийн захиргааны байгууллагаас зохих зөвшөөрөл авдаг	0	9		
20	Газрын тосны тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1 дэх хэсэг	Олборлосон газрын тосны хүргэлтийн цэгийг төрийн захиргааны байгууллага, гэрээлэгч харилцан тохиролцож тогтоодог	0	9		
21	Газрын тосны тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.3 дахь хэсэг	Хүргэлтийн цэг дээр хөндлөнгийн мэргэжлийн байгууллагаар хэмжилт хийлгэдэг	0	9		
22	Газрын тосны тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.6 дахь хэсэг	Олборлолтын туршилт болон олборлолтын явцад олборлосон газрын тосыг хүргэлт болон хяналтын цэг дээр эрх бүхий байгууллагаар баталгаажуулсан хэмжих төхөөрөмжөөр хэмждэг	0	9		
23	Газрын тосны тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.7 дахь хэсэг	Хэмжих төхөөрөмжийн хэвийн үйл ажиллагаа алдагдсан буюу хэмжилт алдаатай хийгдсэн тохиолдолд алдаа гарсан хугацааг хэмжилт алдаатай болсныг мэдсэн өдрөөс өмнө нь хэмжих төхөөрөмжийг хянаж шалгасан өдрийн хоорондох хугацааны дундах өдрөөс эхлэн тооцдог	0	9		
24	Газрын тосны тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.8 дахь хэсэг	Хэмжих төхөөрөмжийн бүрэн бүтэн байдал, байнгын хэвийн үйл ажиллагааг хангах, хяналт тавих зорилгоор мэргэшсэн, хөндлөнгийн байгууллагыг ажиллуулах ба үүнтэй холбогдон гарах зардал, төлбөрийг гэрээлэгч бүрэн хариуцдаг	0	9		

25	Газрын тосны тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.1 дэх заалт	Газрын тос хадгалах байгууламж барьж ашигладаг	0	9		
26	Газрын тосны тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1 дэх хэсэг	Олборлосон газрын тосыг төмөр зам, тусгай зориулалтын автомашин, эсхүл дамжуулах хоолойгоор тээвэрлэдэг	0	9		
27	Газрын тосны тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь хэсэг	Гэрээлэгч газрын тосыг тусгай зориулалтын автомашинаар тээвэрлэх тохиолдолд холбогдох төрийн захиргааны байгууллагаас баталсан замын төрөл, стандартыг мөрддөг	0	9		
28	Газрын тосны тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1 дэх хэсэг, 30.7 дахь хэсэг	Гэрээлэгч тусгай зөвшөөрлийн төлбөрийг жил бүр тухайн санхүүгийн жил эхэлснээс хойш 30 хоногийн дотор төлдөг	0	9		
29	Газрын тосны тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.8 дахь хэсэг	Тусгай зөвшөөрлийн төлбөрийг хуульд заасан хугацаанд төлөөгүй бол хуульд заасан төлбөрийн гуравны нэгтэй тэнцэх торгуулийг хугацаа хэтрүүлсэн хоног тутамд нэмж тооцон төлдөг	0	9		
30	Газрын тосны тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, 31.2 дахь хэсэг	Нөөц ашигласны төлбөр төлдөг	0	9		
31	Газрын тосны тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1 дэх хэсэг	Газрын тостой холбогдсон үйл ажиллагаа явуулахад шаардагдах бүх зардлыг гэрээлэгч хариуцдаг	0	9		
32	Газрын тосны тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.3 дахь хэсэг	Сургалтын урамшуулал, төлөөлөгчийн газрын үйл ажиллагааны дэмжлэгийг төрийн захиргааны байгууллагад шилжүүлдэг	0	9		
33	Газрын тосны тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.4 дэх хэсэг	Орон нутгийг хөгжүүлэх урамшууллыг орон нутгийг хөгжүүлэх санд шилжүүлдэг	0	9		
34	Газрын тосны тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1 дэх хэсэг	Гэрээлэгч ашиглалтын ажлын үр дүнгийн тайлан, анхдагч мэдээ материалыг хуанлийн тухайн жил дууссанаас хойш 90 хоногийн дотор төрийн захиргааны байгууллагад хүлээлгэн өгдөг	0	9		
35	Газрын тосны тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.1 дэх хэсэг	Гэрээлэгч нь тухайн жилд оруулсан хөрөнгө оруулалт, гаргасан зардал, нөөц ашигласны төлбөр, олборлосон болон борлуулсан газрын тосны хэмжээ, улсын болон орон нутгийн төсөвт төлсөн албан татвар, төлбөр, урамшуулал, үйлчилгээний хөлсний хэмжээг дараа оны нэгдүгээр улиралд багтаан холбогдох төрийн захиргааны төв болон төрийн захиргааны байгууллагад хүргүүлж, олон нийтийн мэдээллийн хэрэгслээр мэдээлдэг	0	9		
36	Газрын тосны тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.4 дэх хэсэг	Гэрээлэгч хяналт шалгалтын ажилд шаардагдах мэдээ, мэдээлэл, тайлан материалыг бүрэн гаргаж өгдөг	0	9		

37	Газрын тосны тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1 дэх хэсэг	Гэрээлэгч нь ашиглалтын явцад худаг, өвөлжөө, намаржаа, хаваржаа, хувийн болон нийтийн зориулалттай орон байр, бусад барилга байгууламж, түүх, соёлын дурсгалт зүйл зэрэг бусдын өмчлөл, эзэмшлийн эд хөрөнгөд хохирол учруулсан бол хохирлыг нь бүрэн хэмжээгээр нөхөн төлдөг	0	9		
38	Газрын тосны тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2 дахь заалт	Гэрээлэгч нь ашиглалтын хугацаанд газрын тос, уламжлалт бус газрын тосноос өөр ашигт малтмал илрүүлбэл төрийн захиргааны байгууллагад 15 хоногийн дотор мэдэгддэг	0	9		
39	Газрын тосны тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.3 дахь заалт	Түүхий тос, байгалийн хий, уламжлалт бус газрын тосны болон ашигт малтмалын ашиглалтын үйл ажиллагаа нь давхацсан тохиолдолд тусгай зөвшөөрөл эзэмшигчид харилцан гэрээ байгуулж, бие биеийнхээ үйл ажиллагаанд саад учруулахгүйгээр ажилладаг	0	9		
40	Газрын тосны тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.1 дэх заалт	Нөөц ашигласны төлбөр төлөхгүй байгаа гэрээний тухайд төрийн захиргааны байгууллага гэрээлэгчтэй харилцан тохиролцож уг төлбөрийн хэмжээг тогтоодог	0	9		
41	Газрын хэвлийн тухай хуулийн 38 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1 дэх заалт	Газрын хэвлийг ашиглах явцад аюулгүй ажиллагааны дүрэм, хэм хэмжээг судлуулж мөрдүүлдэг	0	9		
42	Газрын хэвлийн тухай хуулийн 38 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2 дахь заалт	Газрын хэвлийг ашиглах явцад аюул ослоос урьдчилан сэргийлэх, аюул ослын үр дагаврыг арилгах арга хэмжээг төлөвлөж хэрэгжүүлдэг	0	9		
43	Газрын тосны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.3 дахь заалт	Газрын тосны ашиглалтын анхдагч болон үр дүнгийн тайланд тавих шаардлагын дагуу хүргүүлсэн тайлантай	0	9		
44	Газрын тосны тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2 дахь хэсгийн 11.2.1 дэх заалт	Техникийн болон биологийн нөхөн сэргээлтийн ажил MNS 6200:2010 стандартын шаардлага хангасан талаарх дүгнэлттэй	0	9		
45	Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 9-р зүйлийн 9.8 дахь заалт	Тухайн жилийн Байгаль орчны менежментийн төлөвлөгөөтэй	0	9		
46	Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 9-р зүйлийн 9.12 дахь заалт	Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилт, нөхөн сэргээлтийн ажлын гүйцэтгэлд хяналт тавьж, гаргасан дүгнэлттэй	0	9		
47	Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2018 оны А/07 дугаар тушаалаар баталсан "Газрын тосны орд ашиглах үйл ажиллагааны төлөвлөгөөнд тавих шаардлага"-ын 2 дугаар зүйлийн 2.8.14 дэх хэсгийн 2.8.14.1 дэх заалт	Ордыг хаах, татан буулгах үйл ажиллагааны төлөвлөгөө, төсөлтэй	0	9		

48	Уул уурхайн сайдын 2015 оны 49 дүгээр тушаалаар баталсан "Газрын тос, уламжлалт бус газрын тосны эрэл, хайгуул, ашиглалтын анхдагч болон үр дүнгийн тайланд тавих шаардлага"-ын 2 дугаар зүйлийн 2.1 дэх заалт	Тухайн жилд талбайд гүйцэтгэсэн бүх ажлын үр дүнг нэгтгэсэн тайлантай	0	9		
Бүлгийн нийт оноо				396		
49	ДОТООД ХЯНАЛТ					
50	Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2 дахь хэсэг, 13 дугаар зүйлийн 13.1 дэх хэсэг, Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор баталсан Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам	Дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах журмаар батлуулан мөрдөж ажилладаг	0	20		
51		Дотоод хяналт шалгалтын нэгж, ажилтныг томилон ажиллуулсан	0	5		
52		Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд хийгдсэн хяналт шалгалтын талаар бүртгэл хөтөлж, мэдээллийн сан бүрдүүлдэг	0	5		
53		Дотоод хяналт шалгалтаар илэрсэн зөрчлийг нь арилгаж чадахгүй асуудлыг хууль хяналтын эрх бүхий байгууллагад тавьж шийдвэрлүүлэх, хамтран ажиллах талаар санал боловсруулан удирдлагад танилцуулдаг	0	15		
Бүлгийн нийт оноо				45		
НИЙТ ОНОО			0	441	0	0

ХЯНАЛТ ШАЛГАЛТААР АВАХ АРГА ХЭМЖЭЭ, БИЕЛЭЛТ

	ҮНЭЛГЭЭ	Авах арга хэмжээ	БИЕЛЭЛТ
БАТАЛГААЖУУЛАЛТ			
	<i>Хяналтын чиглэл, албан тушаалын нэр</i>	<i>Хяналтын чиглэл, албан тушаалын нэр</i>	<i>Хүлээн зөвшөөрсөн: Аж ахуйн нэгж, байгууллагын эрх бүхий албан тушаалтан</i>
	<i>/ овог, нэр/</i>	<i>/ овог, нэр/</i>	<i>/ овог, нэр/</i>
	<i>/ гарын үсэг, тэмдэг/</i>	<i>/ гарын үсэг, тэмдэг/</i>	<i>/ гарын үсэг, тамга/</i>

Тайлбар:

ГҮЙЦЭТГЭЛИЙН ШАЛГАЛТААР АВСАН АРГА ХЭМЖЭЭ, БИЕЛЭЛТ

	ҮНЭЛГЭЭ	Авах арга хэмжээ	БИЕЛЭЛТ
БАТАЛГААЖУУЛАЛТ			
	<i>Хяналтын чиглэл, албан тушаалын нэр</i>	<i>Хяналтын чиглэл, албан тушаалын нэр</i>	<i>Хүлээн зөвшөөрсөн: Аж ахуйн нэгж, байгууллагын эрх бүхий</i>
	<i>/ овог, нэр/</i>	<i>/ овог, нэр/</i>	<i>/ овог, нэр/</i>
	<i>/ гарын үсэг, тэмдэг/</i>	<i>/ гарын үсэг, тэмдэг/</i>	<i>/ гарын үсэг, тамга/</i>

Тайлбар: